

Биоаюулгүй байдлыг хангах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Биоаюулгүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”-ын тухай Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхийн илтгэл, холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

Биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон бүх төрлийн харилцааг зохицуулах, хяналтыг чангатгах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, биотехнологи, нанотехнологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг дэмжих чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Хоёр. Засгийн газарт:

1. Биоаюулгүй байдлыг хангах урт хугацааны цогц бодлого бүхий үндэсний хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх,
2. Биоаюулгүй байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажилладаг төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлэх,
3. Хувиргасан амьд организмын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж гарах дүрэм, журам, бүтээгдэхүүний стандарт болон биологийн эрсдэл бүхий илгээмж, биобэлдмэл тээвэрлэх, хадгалах журмыг 2011 оны 03 дугаар улиралд багтаан боловсруулан баталж, мөрдүүлэх,
4. Биоаюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилготой биоаюулгүй ажиллагааны гуравдугаар зэрэглэлийн лаборатори байгуулах санхүүжилтийг шийдвэрлэж хэрэгжүүлэх,

5. Хувиргасан амьд организмтай холбоотой шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүх нийтийн боловсрол, мэдлэг олгох сургалт сурталчилгааг эрчимжүүлэх,

6. Молекул биологи, биоанагаах, биотехнологи, нанотехнологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох.